



ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР
Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн
төвлөрүүлэлт, зарцуулалтын үр дүн
ҮАГ- ГАГ/2015/05-ГА/ХөААГ

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторт Хөвсгөл аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовн 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



АЙМАГТ УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН
АЖИЛ ОРХИГДСОН БАЙНА.



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2015 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 1/35

Мөрөг

Аудитын тайлан баталгаажуулах тухай

МУ-ын Ерөнхий аудиторов 2014 оны 121, Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов 2015 оны 04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Цэцэрлэг сумын Засаг дарга, Цагаан-Уул сумын Засаг дарга, Бүрэнтогтох сумын Засаг дарга, Түнэл сумын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2016 оны 04 дүгээр сарын 10-ны дотор багтаан аймгийн Аудитын газарт ирүүлэхийг аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга Р.Жаргалсайхан, Цэцэрлэг сумын Засаг дарга А.Даваадорж, Цагаан-Уул сумын Засаг дарга Д.Түмэнбаяр, Бүрэнтогтох сумын Засаг дарга Б.Намуунцэцэг, Түнэл сумын Засаг дарга Л.Батжаргал нарт зөвлөсүгэй.

4. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын менежер Г.Эрдэнэчимэг, ахлах аудитор Г.Нямлхагва нарт даалгасугай.


ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ГОЮУНГЭРЭЛ

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Аудитын код: УАГ-ГАГ/2015/05-ГА-ХӨААГ

Аудитын нэр: “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт,
зарцуулалтын үр дүн”

Төрийн хяналт шалгалтын стандартад заасны дагуу дээр дурьдсан аудитыг хийж
гүйцэтгэхэд миний зүгээс ажил төрлийн, хувийн болон санхүүгийн ямар нэгэн сонирхлын
зөрчил байхгүй гэдгээ баталж байна.

Ажилтаны		Огноо	Гарын үсэг
Овог нэр	Албан тушаал		
Г.Нямлхагва	Ахлах удитор	2015.10.	
Э.Бат-Эрдэнэ	Шинжээч	2015.10.	

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: <i>ХӨААГ-ын Гүйцэтгэлийн аудитын баг</i> Тэргүүлэх аудитор Г.Оюунгэрэл Утас: 99909224 89905871 Аудитын менежер Г.Эрдэнэчимэг Утас: 99016320 Ахлах аудитор Г.Нямлхагва Утас: 96380550 Багийн гишүүн: Шинжээч Э.Бат-Эрдэнэ Утас: 99857609 2015 оны 7 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043 дугаарын утсаар харилцана уу. Цахим хаяг: Audit.mn ХАЯГ: Мөрөн сум Аймгийн ЗДТГ-ын “А” корпус 3 давхар	Товчилсон үгийн жагсаалт	3
	Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй	4
	Үндсэн мэдээлэл	6
	<i>Бүлэг 1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүйгээс нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ тодорхой бус байна.</i>	
	1.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Могойн гол ХК, Мон-Ажнай ХХК, ШШГА Хорих 443-р анги нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүйгээр үйл ажиллагаа явуулж иржээ.	7
	1.2. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн зардлын 50 хувийг бүрэн төвлөрүүлсэн байна.	9
	<i>Бүлэг 2. Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн зарцуулалтад тавьж буй хяналт хангалтгүй байна.</i>	
	2.1. Хайгуулийн тусгай зөвшөөрөл эзэмшигч “Гоби эксплорэйшн” ХХК, “Монгол ресурс корпораци” ХХК нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийн ажлыг өнөөдрийг хүртэл хийгээгүй байна.	11
	2.2 Цэцэрлэг, Бүрэнтогтох сумдууд нөхөн сэргээлтийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	15
	<i>Бүлэг 3. Хүлээсэн үүргээ биелүүлээгүй ААН, албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллаагүй байна.</i>	
	3.1. Талууд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах цаг нэгэнт болжээ.	17
	3.2. Мэргэжлийн хяналтын газраас өгсөн албан шаардлагыг биелүүлж ажиллаагүйгээс зөрчил давтагдан гарлаа.	19
	Дүгнэлт	21
	Зөвлөмж	22
	Холбогдох байгууллагын санал	
	Саналд өгсөн тайлбар	
	Хавсралт	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
БОНХЯ	Байгаль орчин ногоон хөгжлийн яам
АМГ	Ашигт малтмалын газар
АМХЭГ	Ашигт малтмалын Хэрэг эрхлэх газар
ХөААГ	Хөвсгөл аймгийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ШШГА	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ААН	Аж ахуйн нэгж
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторт өвсгөл аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлийн аудитыг хийв.

Аудит нь дараах зорилтын хүрээнд шалгалт хийж, дүгнэлт гарган зөвлөмж өгөх, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад чиглэгдсэн. Үүнд:

1. Уул, уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу тооцож төвлөрүүлсэн эсэх
2. Төвлөрүүлсэн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу зарцуулсан эсэх
3. Төв орон нутгийн захиргаа, мэргэжлийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хуулиар хүлээсэн үүрэг хэрэгжиж буй эсэх

Аудитад аймгийн ЗДТГ-ын ХБХ, МХГ, БОАЖГ, сумдын ИТХ, Засаг дарга, ЗДТГ, Засаг дарга, байгаль хамгаалагч, уул уурхайн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүд хамрагдлаа.

Аудитын төлөвлөлт болон урьдчилсан судалгаа, түүнд хийгдсэн дүн шинжилгээ, харилцагч байгууллагуудын холбогдох албан тушаалтантай хийсэн ярилцлага, бусад баримт, тулган баталгаажуулалтыг үндэслэн ерөнхий эрсдэлийг “**ДУНД**” гэж үзлээ.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашигласнаас гадна холбогдох газруудад аудитын горимын дагуу асуудлыг шинжлэн судлах, асуулга, ярилцлага хийж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу дэмжлэг болох нотлох зүйлс, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад хамрагдсан хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах хууль, эрх зүйн акт, баримт бичгийг аудитын шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Монгол улсын үндсэн хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Газрын хэвлийн тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Байгууллагын нууцын тухай хууль
- Хувь хүний нууцын тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам
- Уул уурхайн нөхөн сэргээлттэй холбоотой стандартууд:
MNS5914:2008. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томъёо, тодорхойлолт.

MNS5915:2008. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал.

MNS5916:2008. Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт.

MNS5917:2008. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага.

- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

Гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, гүйцэтгэлийн шалгалтын журам, Тэргүүлэх аудиторын баталсан гүйцэтгэлийн аудитын дэд төлөвлөгөөг удирдлага болгон ажиллалаа.

Гүйцэтгэлийн аудитыг Тэргүүлэх аудитор Г.Оюунгэрэл удирдаж, аудитын менежер Г.Эрдэнэчимэг арга зүйгээр ханган, явцын хяналт тавьж, ахлах аудитор Г.Нямлхагва, шинжээч Э.Бат-Эрдэнэ нар 2015 оны 09 дүгээр сарын 01-нээс 2015 оны 10 дугаар сарын 30-ны хооронд хийж гүйцэтгэлээ

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хөвсгөл аймагт 2015 оны 10 дугаар сарын 15-ны байдлаар ашигт малтмалын нийт 50 тусгай зөвшөөрлийг нэр бүхий 26 компани эзэмшиж байна.

Эдгээрээс хайгуулын 33, ашиглалтын 17 тусгай зөвшөөрөл байна.

Аймгийн ИТХ-ын 2009 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор 50 дугаар өргөрөгөөс хойш орших газар нутгийг тусгай хэрэгцээнд авч, энэ нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад ашигт малтмалын ашиглалт, хайгуулын үйл ажиллагаа явуулахыг 5 /тав/ жилийн хугацаатай хориглосон.

Дээрх хугацаа дууссан тул 2014 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 03 дугаар тогтоолоор хугацааг 25 /хорин тав/ жилээр сунгасан байна.

Энэ тогтоолоор Цагааннуур, Ренчинлхүмбэ, Цагаан-Үүр, Улаан-Уул зэрэг сум бүрэн, Алаг-Эрдэнэ сумын зарим хэсэг тусгай хамгаалалтад багтсан.

Аудитын хугацаанд сумдаас ирүүлсэн судалгаа, мэдээлэлд шинжилгээ хийсний үр дүнд уул уурхайн хайгуул болон ашиглалттай холбоотой Цэцэрлэг, Цагаан-Уул, Бүрэнтогтох, Түнэл сумдад 2013 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг хамруулан шалгалаа.



1.1 Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Могойн гол ХК, Мон-Ажнай ХХК, ШШГАлба Хорих 443-р анги нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүйгээр үйл ажиллагаа явуулж иржээ.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1¹-д тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллагаас боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөн ажиллах, төлөвлөгөөнд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээлтэд гарах зардлыг тусгасан байхаар заасан байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.5²-д ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн батлуулж, 39 дүгээр зүйлийн 39.1.6³-д төлөвлөгөөний хуулбарыг тухайн ашигт малтмалын орд байршиж байгаа нутаг дэвсгэрийг харьяалах аймаг, сумын Засаг дарга болон байгаль орчны хяналтын албанд хүргүүлэхээр заасан байгаа ч ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Могойн гол ХК, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба Хорих 443-р анги, Мон-Ажнай ХХК нь өнөөдрийг хүртэл байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгээгүй, энэ байдлаас улбаалаад байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй ба зөвхөн Ашигт малтмалын газраар батлуулсан “Уулын ажлын төлөвлөгөө”-ний дагуу үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.3⁴-д зааснаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч Хургатай хайрхан ХХК, Блек рок ХХК, Монгол ресурс корпарацы ХХК, Чилчиг гол ХХК-ууд нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хайгуулийн талбай орших сумдын Засаг даргаар батлуулсан байгаа ч хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.4⁵, 48 дугаар зүйлийн 48.1.1⁶-д заасны дагуу орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хүргүүлээгүй байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь хуульд

¹ 9.1-д Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага боловсруулна.

² 39.1.5.энэ хуулийн 39.1.1-д заасны дагуу боловсруулсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

³ 39.1.6.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдмагц тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тэдгээрийн хуулбарыг тухайн ашигт малтмалын орд байршиж байгаа нутаг дэвсгэрийг харьяалах аймаг, сум, дүүргийн Засаг дарга болон байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх;

⁴ 38.1.3.энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөг тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж батлуулах;

⁵ 38.1.4.энэ хуулийн 38.1.3-т заасны дагуу батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг хайгуулын талбай байршиж байгаа орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх;

⁶ 48.1.1.хайгуулын ажлын төлөвлөгөөг хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон өдрөөс хойш 30 хоногийн, дараагийн жилүүдэд тухайн оны төлөвлөгөөг 04 дүгээр сарын 15-ны дотор;

заасан үүргээ биелүүлээгүй байхад Ашигт малтмалын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.2⁷-т заасан хариуцлагын арга хэмжээг тооцож ажиллаагүй байна.

Түүнчлэн Ашигт матмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2⁸-т хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь аймгийн Байгаль орчны газраас зөвшөөрөл авч хайгуулын төсөл арга хэмжээг эхлүүлэхээр заасан заалтыг Блек рок ХХК –аас бусад компани хэрэгжүүлээгүй, зөвшөөрөлгүй хайгуулын ажил хийсэн байхад хайгуулын үйл ажиллагааг хориглох арга хэмжээг аваагүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А-36 дугаар тушаалаар “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр тайлан боловсруулах, хянан хүлээн авах, батлах журам”-ыг, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн А-05 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг тус тус баталсан байна.

“Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр тайлан боловсруулах, хянан хүлээн авах, батлах журам”-ын 3.9⁹, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 1.4¹⁰ дахь заалтууд хэрэгжихгүй байгаагаас хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүд боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө харъяа сумын Засаг даргаар батлуулж, БОАЖГ-аар хянуулж батлуулахгүй байна.

Ашигт матмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.8¹¹-д тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон тайланг байгаль орчны хяналтын албанд хүргүүлэхээр заасан заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянаж батлуулах, гүйцэтгэлийг тайлагнах талаарх хууль болон журмын заалтууд хэрэгжихгүй байгаагаас

- байгаль орчны талаарх бодлогыг төлөвлөдөг аймгийн ЗДТГ-ын ХБХ-т тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт,
- байгаль орчны талаарх бодлогыг хэрэгжүүлэгч БОАЖГ-т тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт болон “Блекрок” ХХК-ийн 2014 оны тайлан, 2015 оны төлөвлөгөө,
- хэрэгжилтэд хяналт тавьж буй МХГ-т 2013-2015 онуудад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт хийсэн шалгалтын танилцуулгаас өөр баримт материалгүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлд аймаг, сум мэдээллийн сантай байх, 35 дугаар зүйлд 35.2-т мэдээллийн сангийн бүрэлдэхүүнд ашигт малтмалын талаарх мэдээлэл багтсан байхаар заасан байна.

⁷ 66.1.2.энэ хуулийн 48 дугаар зүйлд заасан мэдээ, төлөвлөгөө, ашиглалтын үйл ажиллагааны тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

⁸ 37.2.Байгаль орчны албанаас зөвшөөрөл авалгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, үйл ажиллагаа эхлэхийг хориглох бөгөөд тухайн асуудлаар маргаан гарвал мэргэжлийн хяналтын байгууллагад гомдол гаргаж болно.

⁹ Төлөвлөгөөг төв байгууллагад БОАЖЯ-ны ХБОБНГ-ын мэргэжилтэн бүртгэж, газрын орлогч дарга хянаж, газрын даргаар батлуулна, аймаг нийслэлд байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга баталж, холбогдох мэргэжилтэн хянаж бүртгэнэ.

¹⁰ Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны алба хянаж, батална.

¹¹ 48.8 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ.

Энэхүү мэдээллийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2¹²-т заасны дагуу аймгийн ЗДТГ-ын ХБХ, БОАЖГ нь улсын мэдээллийн санд төвлөрүүлэхээр заасан байтал өнөөдрийн байдлаар аймагт мэдээллийн сан байхгүй байгаагаас ямар мэдээллийг төвлөрүүлж байгаа нь тодорхойгүй байна. Энэ үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн холбогдох албан тушаалтанд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 5¹³-д заасны дагуу арга хэмжээ ногдуулахаар заажээ.

Мөн холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна. Тухайлбал:

- АМГ-аас ирүүлсэн судалгаагаар И Эй Эм тэшиг ХХК, Дасмондрил ХХК, Юнайтедминералс ХХК, Звездамерика ХХК, Мон-Ажнай Вольфрам монголиа майнинг ХХК-иуд нь 2013-2015 онуудад хайгуулын ажлын төлөвлөгөөгөө АМГ-т ирүүлсэн байна. Гэтэл сумдуудад хийсэн тулган баталгаажуулалт болон сумдуудаас ирүүлсэн мэдээллээр эдгээр компаниуд нь сүүлийн жилүүдэд хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй байна.
- Аймгийн БОАЖГ-аас 2015 оны 5 дугаар сарын 26-нд Ашигт малтмалын газраас тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хаяг, холбоо барих утсыг ирүүлэхийг хүссэн 230 дугаар тоотыг, мөн оны 1 дүгээр сард сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт хамтран ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн байна.

1.2 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн зардлын 50 хувийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлынхаа 50 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг тусгай дансанд байршуулахаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Ашигт малтмалын тухай хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-04 дүгээр тушаалаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-д тус тус заасан байна. Үүнд:

1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9¹⁴, Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.8¹⁵-д заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Хургатай хайрхан” ХХК, “Блек рок” ХХК, “Монгол ресурс корпораци ХХК” ХХК, “Чилчиг гол” ХХК-ууд нь сумын Засаг даргаар батлуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтэд зарцуулах хөрөнгийн 50 хувь болох 25,35 сая

¹² Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан мэдээллийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

¹³ 5/ энэ хуулийн 37, 40 дүгээр зүйлд заасны дагуу холбогдох мэдээллийг улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн мэдээллийн санд төвлөрүүлээгүй, мэдээллийн санд өгөх тайлан, мэдээллийг энэ хуульд заасан хугацаанд гаргаж өгөөгүй, бол холбогдох албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний, төгрөгөөр торгох;

¹⁴ 9.9.Энэ хуулийн 9.10-т зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана.

¹⁵ 38.1.8-д байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх.”

төгрөгийг Цэцэрлэг, Цагаан-Уул, Бүрэнтогтох сумдын Байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн байна. Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө төвлөрүүлсэн байдлыг хүснэгт 1-ээр үзүүлбэл:

Хүснэгт 1

№	Сумдын нэр	ААН-ийн нэр	Тусгай зөвшөөрлын дугаар	Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө /оноор, сая.төг/			Нийт дүн /сая.төг/
				2013 он	2014 он	2015 он	
1	Бүрэнтогтох	Чилчиг гол	ХҮ-012816	0.5	0.5	0.5	1.5
		“Блэкрок” ХХК	ХҮ-013580	0.5	1.5	1.5	3.5
		“Блэкрок” ХХК	ХҮ-013958	-	1.5	1.5	3.0
		Эм Жи Ти Жи	ХҮ-014026	-	0.5	-	0.6
		Эй Си Ти Эс	ХҮ-015006	0.05	-	-	0.05
		Эй Си Ти Эс	ХҮ-015384	0.05	-	-	0.05
		Талст маргад		1.4	-	-	1.4
Нийт			2.5	4.0	3.5	10.0	
2	Цагаан-Уул	“Хургатай хайрхан” ХХК	ХҮ-014510	2.0	2.0	2.0	6.0
		“Монгол Ресурс корпораци” ХХК	ХҮ-016751	0.4	0.5	-	0.9
		Нийт			2.4	2.5	2.0
3	Цэцэрлэг	“Хургатай хайрхан” ХХК	ХҮ-013636	1.0	1.0	1.0	3.0
			ХҮ-014510	-	1.0	1.0	2.0
		Овоот Коал Майнинг ХХК	ХҮ-017003	1.0	1.0	1.0	3.0
		“Могойн гол ресурс” ХХК	ХҮ-014191	-	0.45	-	0.45
		Нийт			2.0	3.45	3.0
Нийт дүн				6.9	9.95	8.5	25.35


2. Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5¹⁶-д барьцаа хөрөнгийн 50 хувийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн олборлолтын ажил эхлэхийн өмнө төвлөрүүлэхээр заасан байтал ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Могойн гол ХК, Мон-Ажнай ХХК, ШШГА Хорих 443-р анги нь өнөөдрийг хүртэл төвлөрүүлээгүй ба байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй тул төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ тодорхойгүй байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулсан бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3¹⁷-д заасан торгуулийн арга хэмжээ, нөхөн сэргээлийн барьцаа хөрөнгийг төвлөрүүлээгүй бол Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6¹⁸-д заасны дагуу тухайн сумын Засаг дарга олборлолтын ажлыг зогсоохоор заасан байна.

¹⁶ 39.5.Энэ хуулийн 39.3-т заасан мөнгөн хөрөнгийг тухайн жилийн олборлолтын ажил эхлэхийн өмнө шилжүүлэх бөгөөд энэхүү шилжүүлэг хийгдсэн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэнэ

¹⁷ 19.1.3.байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25-30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох

¹⁸ 39.6.Энэ хуулийн 39.5-д заасан хугацаанд мөн хуулийн 39.1.9-д заасан мөнгөн хөрөнгийг шилжүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга уурхайн тухайн жилийн олборлолтын ажлыг зогсоох эрхтэй.



2.1. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Гоби эксплорэйшн” ХХК, “Монгол ресурс корпораци” ХХК нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийн ажлыг өнөөдрийг хүртэл хийгээгүй байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчныг хамгаалах болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хүрээлэн байгаа орчны бохирдолтыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээг тусган мөрдөж ажиллахыг Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.2¹⁹, Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-05 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах, батлах, тайлагнах журам”-ын 1.5²⁰-д тус тус заасан байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч Хургатай хайрхан ХХК, Блек рок ХХК, Эй Си Ти Эс ХХК, Чилчиг гол ХХК-ууд нь сумын Засаг даргаар батлуулсан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж, сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагчаар “байгаль орчинд ямар нэг сөрөг нөлөө үзүүлээгүй үүргээ гүйцэтгэж, хайгуул хийсэн талбайгаа зохих хуулийн дагуу хүлээлгэж өгсөн” гэсэн дүгнэлт гаргуулсан байна.

Хайгуулийн тусгай зөвшөөрөл эзэмшигч “Гоби эксплорэйшн” ХХК, “Монгол ресурс корпораци” ХХК нь Цагаан уул сумын Өвгөд багийн нутаг дэвсгэрт 2360.11 гектар талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулсан бөгөөд хөндсөн талбайд батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийн ажлыг өдийг хүртэл хийгээгүй байна. Зургаар харуулбал:

Зураг 1



Хайгуулын үйл ажиллагаа явуулсан талбайн ерөнхий байдал

Зураг 2



Ажил гүйцэтгэсэн газарт хог хаясан байдал

¹⁹ 38.1.2.энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөнд хүрээлэн байгаа орчны бохирдолтыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээг тусгах;

²⁰ 1.5.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан байна.

Зураг 3



Модны захруу шахаж өрөмдлөг хийсэн газар

Зураг 4



Өрөмдлөг хийхийн тулд гаргасан зам

Зураг 5



Өрөмдлөг хийсэн байдал

Зураг 6



Модон дотор өрөмдлөг хийсэн байдал

Сум орон нутгийн удирдлагууд хайгуулын явцад хөндсөн газрыг нөхөн сэргээх талаар “Монгол ресурс корпораци” ХХК-д удаа дараа хандсан ч шаардлагыг биелүүлээгүй байна. Сумын ИТХ-ын хуралдааны 2013 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 05 дугаар тогтоолд *“Тусгай зөвшөөрөл эзэмшигч Монгол ресурс корпораци ХХК, Гоби эксплорэйшн ХХК нь Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 40 дүгээр зүйлийн 40.1-д заасан үүргээ биелүүлээгүй, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг ноцтой зөрчиж байгаа тул Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тусгай зөвшөөрлийг цуцлуулах саналыг хүргүүлсүгэй”* гэж дурьдаад уг тогтоолыг Ашигт малтмалын газар болон Байгаль орчин ногоон хөгжлийн сайд С.Оюунд хүргүүлсэн байна. Эдгээр тоотын хариуд

1. Ашигт малтмалын газрын 2013.03.06-ны өдрийн №6-1057 албан тоот: *“Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчин нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Байгаль орчин ногоон хөгжлийн яам) дүгнэлт гаргасан тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлахаар Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д хуульчлан заасан тул танайхаас ирүүлсэн албан бичиг, холбогдох материалаар 10844Х, 16751Х тоот тусгай зөвшөөрлүүдийг цуцлах хуулийн үндэслэлгүй бөгөөд зөвхөн Ашигт*

малтмалын тухай хуулийн 56-р зүйлийн 56.1.1-56.1.5-д заасан үндэслэлүүдээр цуцлах боломжтой болохыг уламжлъя гэжээ.

2. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдаас 2013.04.19- ны өдрийн №1/1797 албан тоот: “Танай сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй Гоби эксплорэйшн ХХК, Монгол ресурс корпорацийн үйл ажиллагаатай холбогдох асуудлыг хянан үзэхэд, дээрхи аж ахуйн нэгжүүдийн эзэмшлийн ХҮ-016751, 10844Х дугаартай тусгай зөвшөөрлийн талбайн тодорхой хэсэг нь ойн сан бүхий газарт орсон байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох болон цуцлах асуудал Уул уурхайн яамны чиг үүрэгт хамаардаг. Иймд дээрхи аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах асуудлаар Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 зүйлийн 2.4 заалтын дагуу Ашигт малтмалын газарт хандах нь зүйтэй” гэжээ.

БОНХЯ болон АМГ-аас дээрх хариуг ирүүлсэн ба өнөөдрийг хүртэл тодорхой арга хэмжээ авагдаагүй, нөхөн сэргээлт хийгдээгүй байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5²¹-д байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын /Байгаль орчин ногоон хөгжлийн яам/ дүгнэлтийг үндэслэн төрийн захиргааны байгууллага /Ашигт малтмалын газар/ тусгай зөвшөөрлийг цуцлахаар заасан байна.

БОНХЯ-аас ирүүлсэн тоотод “Гоби эксплорэйшн ХХК, Монгол ресурс корпорацийн үйл ажиллагаатай холбогдох асуудлыг хянан үзэхэд, дээрхи аж ахуйн нэгжүүдийн эзэмшлийн ХҮ-016751, 10844Х дугаартай тусгай зөвшөөрлийн талбайн тодорхой хэсэг нь ойн сан бүхий газарт орсон байна.” гэснээс харахад уг тусгай зөвшөөрөл нь Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны нөөц бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4.1²², 4.5²³ дах заалтыг зөрчин тусгай зөвшөөрлийг олгосон байна.

Мөн Мон-Ажнай ХХК-ийн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй газар нь усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд /Дэлгэр мөрөн гол/ орсон байна.

Цэцэрлэг сумын нутаг дэвсгэрт байрлах “Могойн гол” ХК нь “Уулын ажлын төлөвлөгөөгөөр 2013, 2014 ондуудад 9,5 га-д техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн ч тулган баталгаажуулалтаар 2013 онд 2 га, 2014 онд 1,2 га-д нөхөн сэргээлт хийсэн ба нөхөн сэргээлтийн ажлын тайланг суманд хүлээлгэж өгсөн актгүй байна.

Бүрэнтогтох сумын нутаг дэвсгэрт байрлах ХҮ-013580 хайгуулын зөвшөөрөлтэй “Блэкрок” ХХК нь 2014 онд нөхөн сэргээлт хийсэн тухай ажлын тайлан байгаа ч орон нутагт хүлээлгэж өгсөн акт, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн дүгнэлтгүй байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.1²⁴-д уурхайг хаах үед уурхайн талбайг нийтийн зориулалтаар ашиглахад аюулгүй болгох, байгаль орчныг нөхөн сэргээх талаар холбогдох арга хэмжээг бүрэн авсан байхаар заасан байгаа ч ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дээрх ААН-үүд байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй, нөхөн сэргээх зардлын 50 хувийг төвлөрүүлээгүй,

²¹ 56.1.5. тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан.

²² 4.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно.

²³ 4.5. Энэ хуулийн 4.1-д заасан газарт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй.

²⁴ 45.1.1. Уурхайн талбайг нийтийн зориулалтаар ашиглахад аюулгүй болгох, байгаль орчныг нөхөн сэргээх талаар холбогдох арга хэмжээг бүрэн авах;

эвдэрсэн газар болон овоолгод нөхөн сэргээлт хийгээгүй зэргээс харахад уурхайг хаах үед нөхөн сэргээлтийг бүрэн хийж чадахгүйд хүрэх эрсдэл ойрхон байна.

Зураг 7



ШШГА Хорих 443-р ангийн ашиглагдахгүй байгаа талбай

Зураг 8



Могойн гол ХК-ны гадаад овоолго

Зураг 9



Мон Ажнай ХХК-ны уурхайн ашиглалтын байдал, гадаад овоолго

Зураг 10



Зураг 11



Зураг 12



Мон Ажнай ХХК-ны уурхайн ашиглалтын байдал, гадаад овоолго

2.2. Цэцэрлэг, Бүрэнтогтох сумдад нөхөн сэргээлтийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.15²⁵, Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8²⁶-д заасны дагуу Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-04 дүгээр тушаалаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ыг баталсан байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх үүргийн баталгаа болгон тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг Ашигт малтмалын тухай хуулийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ бүрэн биелүүлсэн үед буцаан олгох тухай Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4²⁷, 39 дүгээр зүйлийн 39.4²⁸, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-04 дүгээр тушаалаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 3.1²⁹, 3.2³⁰-д тус тус заасан бол журмын 5.5³¹-д тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг журамд зааснаас өөр зүйлд зарцуулахыг хориглосон байна.

Өнөөдрийн байдлаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд орон нутгийн тусгай дансанд 25,35 сая төгрөг төвлөрснөөс 19,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Зарцуулалтыг 2015 оны 10 дугаар сарын 15-ны байдлаар хүснэгт 2-оор үзүүлбэл:

Хүснэгт 2			
Сумдын нэр	Тусгай дансанд төвлөрсөн нийт хөрөнгө /сая.төг/	Тусгай дансны үлдэгдэл /сая.төг/	Зарцуулалт /сая.төг/
Бүрэнтогтох	10.0	9.2	0.8
Цагаан-Уул	6.9	6.9	
Цэцэрлэг	8.45	3.6	4.8
Нийт дүн	25.35	19.7	5.6

Хүснэгтээс харахад тусгай санд төвлөрүүлсэн барьцаа хөрөнгөөс 5.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Сумдын төрийн сангийн төлөөлөгчид орон нутагт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ээс жил бүр төвлөрч буй нөхөн сэргээлтийн баталгаа болох мөнгөн хөрөнгийн тайланг боловсруулдаггүй, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлдэггүй, нөхөн сэргээлт хийсний дараа буцаан олгох барьцаа хөрөнгийг өглөгөөр тусгаагүй зэргээс үүдэн нөхөн сэргээлтийн баталгаа болох мөнгөн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдаж байна.

²⁵ 9.15. Энэ хуулийн 9.9, 9.10-т заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

²⁶ 39.8.Энэ хуулийн 38.1.8, 39.1.9-д заасан тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.


²⁷ 38.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн бол энэ хуулийн 38.1.8-д заасан хөрөнгийг түүнд буцааж өгнө.

²⁸ 39.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн бол энэ хуулийн 39.1.9-д заасан хөрөнгийг түүнд уурхайн хаалтын үе шатанд буцааж өгнө.

²⁹ 3.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлсэн бүх төрлийн ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх төсөл хэрэгжүүлэгчид тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэлийг харгалзан буцаан олгоно.”

³⁰ 3.2. Дээрхээс бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгчид тусгай дансанд байршуулсан хөрөнгийг тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэлийг харгалзан буцаан олгоно.

³¹ 5.5. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг энэхүү журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.



3.1. Талууд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах цаг нэгэнт болжээ.

Төв, орон нутгийн захиргаа, мэргэжлийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчинг хамгаалах, нөхөн сэргээлттэй холбоотой хүлээх үүрэг, хариуцлагыг холбогдох хууль журамд тодорхой тусгасан байна. Үүнд:

А. Төв, орон нутгийн захиргааны хүлээх эрх, үүргийн талаар

1. Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн “Уулын ажлын төлөвлөгөө”-г батлахдаа байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан эсэхийг хянахгүй байна.
2. Мөн тусгай зөвшөөрөл эзэмшигч нараас хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хүлээн авахдаа “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр тайлан боловсруулах, хянан хүлээн авах, батлах журам”-ын 5.1³²-д заасан баримт материалыг шаардаж авахгүй байгаагаас төв, орон нутгийн байгууллагын хоорондын болон тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-үүдтэй харьцах харьцаа хангалтгүй байна.
3. Аймгийн байгаль орчны газар нь “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр тайлан боловсруулах, хянан хүлээн авах, батлах журам”-ын 3.9³³, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 1.4³⁴, “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр тайлан боловсруулах, хянан хүлээн авах, батлах журам”-ын 6.1³⁵, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3.4³⁶ -д заасан тухайн жилийн менежментийн төлөвлөгөөг хянаж батлах үүргээ хэрэгжүүлээгүй.
4. БОАЖГ-ын мэргэжилтний гаргаж АМГ-т хүргүүлсэн нөхөн сэргээлтийн 2013, 2014 оны тайлан мэдээ нь бодит байдал дээр зөрүүтэй байна. Тухайлбал:
 - Нөхөн сэргээлтийн дансанд төвлөрүүлсэн барьцаа хөрөнгийг жил бүр 3,2 сая төгрөг гэсэн бол тулган баталгаажуулалтаар нийт 23,35 сая төгрөг төвлөрсөн байна.
 - Могойн гол ХК нь жил бүр 27 га-д техникийн нөхөн сэргээлт хийдэг гэсэн мэдээ гаргасан ба тулган баталгаажуулахад 2013, 2014 онд нийт

³² Тухайн аймгийн Байналь орчин аялал жуулчлалын газрын байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх талаар хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, хэрэгжилтэд өгсөн урьдчилсан үнэлэлт, хэрэгжилтийн хувийг тооцсон материалын талаарх албан бичиг

³³ Төлөвлөгөөг төв байгууллагад БОАЖЯ-ны ХБОБНГ-ын мэргэжилтэн бүртгэж, газрын орлогч дарга хянаж, газрын даргаар батлуулна, аймаг нийслэлд байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга баталж, холбогдох хянаж бүртгэнэ.

³⁴ Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны алба хянаж, батална.

³⁵ Өмнөх оны төлөвлөгөө хөтөлбөрийн хэрэгжилтийг хүлээн авч дүгнэх, тухайн жилийн төлөвлөгөө хянаж батлах ажлыг төв байгууллагад Байгаль орчин аялал жуулчлалын яамны Хүрээлэн уй орчин, байгаагийн нөөцийн газар, аймаг нийслэлд Байгаль орчин аялал жуулчлалын газар гүйцэтгэнэ.

³⁶ Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батална.

3.2 га-д биологийн нөхөн сэргээлт хийсэн ба орон нутагт хүлээлгэж өгсөн актгүй байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.2³⁷-д хуурамч мэдээ тайлан гаргасан албан тушаалтанд торгох арга хэмжээ ногдуулахаар заасан байна.

5. Сумын Засаг дарга нар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлахаас өөр эрх, үүргийг хэрэгжүүлэхгүй байна. Тухайлбал:

- Сумдын Засаг дарга нар сумын ИТХ-д байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх талаар хийсэн ажлын тайлангаа хэлэлцүүлээгүй байна.
- Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.4, 39.5-д заасны дагуу байгаль орчны нөхөн сэргээлтийн зардлын барьцаа хөрөнгийг байршуулсан талаар Засаг даргад мэдэгдээгүй тохиолдолд 39.6³⁸-д заасны дагуу үйл ажиллагааг нь зогсоох эрхтэй байтал энэхүү эрхээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

6. Сумын төрийн сангийн төлөөлөгч нь Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын 4.1³⁹ заасны дагуу тайлангаа ИТХ-аар хэлэлцүүлж, Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлээгүй байна. Журмыг зөрчсөн албан тушаалтанд Төсвийн тухай болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэхээр журмын 5.6⁴⁰-д заасан байна.

Б. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг:

1. Тусгай зөвшөөрөл эзэмшиж буй Могойн гол ХК, Мон ажнай ХХК, ШШГА Хорих 443-р анги, “Монгол ресурс корпораци” ХХК, “Топруонхэнцэ” ХХК, “Сутайхэнцэ” ХХК, “Талст маргад” ХХК-ууд нь 2013, 2014, 2015 онуудад байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулаагүй, байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байгаль хамгаалах санд жил бүр байршуулах зэрэг хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхгүй байна.
2. Тусгай зөвшөөрөл эзэмшиж буй ААН-үүд нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулаад, аймгийн БОАЖГ-аар батлуулахгүй байгаа нь “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 1.4-д заасан заалтыг хэрэгжүүлэхгүй ба батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний биелэлт болон тайланг ашигт малтмалын тухай хуулийн 38.1.5⁴¹, 39.1.7⁴²-д заасны дагуу холбогдох албанд хүргүүлэхгүй байна.

³⁷ 66.1.2.энэ хуулийн 48 дугаар зүйлд заасан мэдээ, төлөвлөгөө, ашиглалтын үйл ажиллагааны тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

³⁸ 39.6.Энэ хуулийн 39.5-д заасан хугацаанд мөн хуулийн 39.1.9-д заасан мөнгөн хөрөнгийг шилжүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга уурхайн тухайн жилийн олборлолтын ажлыг зогсоох эрхтэй.

³⁹ 4.1.Сум, дүүргийн Төрийн сангийн тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын жилийн тайланг тухайн сум, дүүргийн төрийн сангийн төлөөлөгч жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, 12 дугаар сарын 20-ны дотор Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

⁴⁰ 5.6.Энэхүү журмыг зөрчсөн Төрийн сангийн болон төсвийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд “Төсвийн тухай” болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

⁴¹ 38.1.5.хайгуулын ажлын явцад үүссэн байгаль орчны сөрөг нөлөөллийг тухай бүр бүртгэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний жилийн тайланд тусгах бөгөөд уг тайланг байгаль орчны хяналтын алба болон тухайн сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх;

⁴² 39.1.7.уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан сөрөг нөлөөллийг тухай бүр бүртгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон тайланг жил бүр гарган байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд тус тус хүргүүлэх.

3. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж буй ашиглалт явуулж буй “Могойн гол” ХК, ШШГА Хорих 443-р анги, “Мон ажнай” ХХК-ууд нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгээгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулаагүй зэрэг Ашигт малтмалын тухайн хуулийн 39⁴³ дүгээр зүйлд заасан заалтуудыг баримталж ажиллаагүй байна.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 42.1⁴⁴-д заасны дагуу орон нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллаагүй байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 19.1.1⁴⁵-д байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, зохих шийдвэргүйгээр ажилласан бол үйл ажиллагааг зогсоож, олсон орлогыг төсвийн дансанд шилжүүлэх, 19.1.3⁴⁶-т байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, биелэлтийг холбогдох газарт тайлагнаагүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоор, Ашигт малтмалын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.4⁴⁷-т тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахдаа байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол торгуулийн арга хэмжээ авч, хохирлыг нөхөн төлүүлэхээр тус тус заасан байна.

Ийнхүү талууд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байхад байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, сумдын Засаг дарга, Мэргэжлийн хяналтын газар хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд арга хэмжээ авч ажиллаагүй байна.

3.2. Мэргэжлийн хяналтын газраас өгсөн албан шаардлагыг биелүүлж ажиллаагүйгээс зөрчил давтагдан гарлаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.12⁴⁸, Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3⁴⁹, 12.1.3⁵⁰-д бүх шатны Засаг дарга, Мэргэжлийн хяналтын газар, тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина гэж заасан байна.

- Аудитад хамрагдсан Бүрэнтогтох, Цагаан-Уул, Цэцэрлэг сумдын Засаг дарга нар орон нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Могойн гол” ХК, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газар, “Мон-Ажнай” ХХК-ууд байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулахгүйгээр ашиглалтаа явуулсаар байхад орон нутгийн удирдлага хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хяналт хийгээгүй байна.

⁴³ Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг

⁴⁴ 42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

⁴⁵ 19.1.1.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, зохих шийдвэр гаргуулалгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол хууль бус үйл ажиллагааг зогсоож, хууль бусаар олсон орлогыг хурааж сум, дүүргийн төсвийн дансанд шилжүүлэх;

⁴⁶ 19.1.3.байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25-30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох

⁴⁷ 66.1.4.энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан нийтлэг үүргийг биелүүлээгүй албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;

⁴⁸ 9.12 Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина.

⁴⁹ 11.3.Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэнэ.

⁵⁰ 12.1.3.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих

- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А-36 дугаар тушаалаар “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр тайлан боловсруулах, хянан хүлээн авах, батлах журам”-ын 3.3⁵¹-д заасан төлөвлөгөөний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах үүргээ хэрэгжүүлээгүй байна.
- Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас жил бүр ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн гурван ААН-дэд илэрсэн зөрчлийг арилгах талаар хугацаатай албан шаардлага хүргүүлсэн боловч албан шаардлагын биелэлт хангалтгүй байна. Тухайлбал:
 - ✓ Могойн гол ХК-д 2014 онд хийсэн шалгалтаар эвдэрсэн газар болон овоолгод нөхөн сэргээлт хийгээгүй зөрчил илэрч нөхөн сэргээлтийг хийх даалгавар өгсөн бол 2015 онд хийсэн шалгалтаар нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй гэж дүгнээд тухайн жилийн уулын ажлын болон байгаль хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг гаргах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээж, орон нутагт хүлээлгэн өгч хариуг 2015 оны 6 дугаар сарын 01-ний дотор мэдэгдэх албан шаардлага хүргүүлсэн байна.
 - ✓ ШШГА Хорих 443-р ангид 2014 онд хийсэн шалгалтаар өмнөх онд гарч байсан зөрчил болох уулын ажлын болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулаагүй, төлөвлөгөөгүй олборлолт хийсэн, эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийгээгүй зэрэг зөрчил давтан гарч, зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн. 2015 онд хийсэн шалгалтаар мөн уулын ажлын болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулсан, нөхөн сэргээлт хийгдээгүй зөрчил давтагдан гарч зөрчлийг арилган 2015 оны 6 сард хариу ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн. ШШГА Хорих 443-р ангиас “2015 онд хийгдэх “Уулын ажлын төлөвлөгөөг боловсруулан АМГ-т хүргүүлсэн боловч хайгуул хийж нөөц тогтоогдоогүй, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдээгүй гэсэн шалтгаанаар батлаагүй” гэсэн хариу ирүүлсэн байна.
 - ✓ Мон-Ажнай ХХК-д 2014 онд хийсэн шалгалтаар байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй, нөхөн сэргээлт хийгдээгүй зэрэг зөрчил илэрч 2015 оны уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө хариу ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн байна. 2015 онд хийсэн шалгалтаар нөхөн сэргээлт хийгдээгүй, нөхөн сэргээлийн барьцаа хөрөнгийг төвлөрүүлээгүй зөрчил илэрсэн байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-үүдийн тухайд 2014, 2015 онд МХГ-аас хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил өнөөдрийг хүртэл байсаар байхад Ашигт малтмалын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.5⁵²-д заасан арга хэмжээг авч ажиллаагүй байна.

⁵¹ 3.3.Төсөл хэрэгжүүлэгчээс тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээж авсан аймаг, нийслэлийн Байгаль орчны газар түүний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулж, ажилуулан дүгнэлтийг 12 дугаар сарын 1-ний дотор гаргуулах ба уг ажлын хэсэгт аймаг нийслэлийн Засаг даргын тамгын газрын хөгжлийн бодлогын хэлтэс, байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын газар, сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын төлөөлөл, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал орно.

⁵² 66.1.5. ашигт малтмал эрэх, хайх, ашиглах ажиллагааны явцад илэрсэн зөрчлийг арилгуулахаар эрх бүхий улсын байцаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй бол албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь хууль, журамд заасны дагуу батлагдахгүй байгаагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчийн жагсаалтаас өөр мэдээлэл төрийн болон мэргэжлийн байгууллагад байхгүй байна.
2. 2013-2015 оны байдлаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн зардлын 50 хувь 25,3 сая төгрөгийг орон нутгийн байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн бол ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-үүд нөхөн сэргээлтийн зардлын 50 хувийг Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлээгүй байна.
3. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-үүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүйгээс нөхөн сэргээх зардлын барьцаа болох 50 хувийг төвлөрүүлээгүй, овоолгод нөхөн сэргээлт хийгээгүй байгаа зэргээс харахад уурхайг хаах үед нөхөн сэргээлтийг бүрэн хийж чадахгүйд хүрэх эрсдэл ойрхон байна.
4. Орон нутгийн тусгай дансанд төвлөрсөн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгөөс Цэцэрлэг сум 4.7 сая төгрөг, Бүрэнтогтох сум 0.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байхад сумдын Засаг дарга, Мэргэжлийн хяналтын газар хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд арга хэмжээ авч ажиллаагүй байна.
6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь зөрчил арилгуулах талаар өгсөн Мэргэжлийн хяналтын газрын албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс өнөөдрийг хүртэл байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүйгээр үйл ажиллагаа явуулж байна.



Аудитын дүнд үндэслэн дор дурдсан байгууллагад дараах зөвлөмжийг өгч байна.

1. Ашигт малтмалын газарт

- 1.1 Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн “Уулын ажлын төлөвлөгөө”-г батлахдаа байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан эсэхийг хянаж байх.
- 1.2 Уулын ажлын төлөвлөгөөг батлахдаа шаардагдах баримт материалыг бүрэн гаргуулан авч байх.
- 1.3 Ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан үүргийн биелэлтийг баталгаажуулсан тайланг аймгийн БОАЖГ-т хүргүүлж байх

2. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт

- 2.1 Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон сумдын Засаг дарга, бусад холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллах, мэдээллээ солилцож байх
- 2.2 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан баталж, хэрэгжилтэд хяналт тавьж тайланг холбогдох газарт хүргүүлж байх.
- 2.3 Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаар мэдээллийн сантай болох

3. Сумдын Засаг дарга нарт

- 3.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахдаа
 - Аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газраар батлуулсан, зөвшөөрөл авсан эсэхийг хянах,
 - Өмнөх оны төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцож байх.
- 3.2 Ашигт малтмалын тухай хуулиар олгогдсон эрх үүргийн дагуу хяналт тавьж, илэрсэн зөрчийг тухай бүрт нь арилгах, ажлын тайланг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн холбогдох газарт хүргүүлж байх
- 3.3 Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон бусад холбогдох байгууллагатай хамтран ажиллах
- 3.4 Нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулсан барьцаа хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнаж байх
- 3.5 Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаар мэдээллийн сантай болох
- 3.6 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нөхөн сэргээлт хийсэн талбайг ажлын хэсэг томилон хүлээн авч, акт үйлдэж байх

4. Аймгийн МХГ, БОАЖГ, сумдын Засаг дарга нарт

- 4.1 Аймгийн ИТХ-ын хуралдаанаар тусгай хамгаалалтад авсан нутаг дэвсгэрт олгогдсон тусгай зөвшөөрлүүдийг цуцлуулах талаар холбогдох газарт саналаа хүргүүлэн ажиллах
- 4.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулж байгаа болон байгаль хамгаалах талаар төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээгээ авч ажиллаагүй тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт хуулийн дагуу арга хэмжээ авах саналаа холбогдох газарт хүргүүлэн ажиллах

5. Сумдын санхүүгийн албаны дарга нарт

- 5.1 Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах
- 5.2 Барьцаа хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалтын тайланг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн холбогдох газарт хугацаанд нь хүргүүлж байх
- 5.3 Барьцаа хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу өглөгөөр бүртгэж байх

6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт

- 6.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг холбогдох газраар батлуулан, хүргүүлж байх.
- 6.2 Нөхөн сэргээлт хийгдсэн талбайг сумын Засаг даргын томилсон ажлын хэсэгт хүлээлгэн өгч байх
- 6.3 Хяналт шалгалтын мөрөөр өгсөн албан шаардлага, үүрэг даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах
- 6.4 Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумын Засаг дарга болон бусад холбогдох байгууллагатай хамтран ажиллах
- 6.5 Барьцаа хөрөнгийг хугацаанд нь холбогдох дансанд төвлөрүүлж байх.

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

Нэг. Төлбөрийн акт

/сая төгрөг/

№	Байгууллага	Төлбөр хариуцагчийн		Зөрчлийн товч утга	Актын дугаар	Зөрчлийн дүн /сая төг/
		Нэр	Албан тушаал			
1	Бүрэнтогтох	Б.Намуунцэцэг	Засаг дарга	Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан		0,8
2	Цэцэрлэг	А.Даваадорж	Засаг дарга			4,8
		Нийт дүн				5,6

Хоёр. Бусад

/сая төгрөг/

№	Холбогдох албан тушаалтан	Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн
1	БОАЖГ-ын дарга, мэргэжилтэн	1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж, батлаагүй. 2. Нөхөн сэргээлтийн мэдээ тайланг буруу гаргасан. 3. Мэдээллийн сан байхгүй. 4. Холбогдох газруудтай хамтарч ажиллаагүй	
2	Сумын Засаг дарга, БОХУБ, байгаль хамгаалагч	1. Хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хяналт тавьж, арга хэмжээ авч ажиллаагүй. 2. Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан. 3. Нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээж авах комисс томилоогүй.	
3	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй. 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг холбогдох газар хүргүүлээгүй 3. МХГ-аас хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй	
	Нийт дүн		

Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар



АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аудитын тайланд өгөх санал

УИХ-ын Төсвийн байнгын хорооны захиалгаар хийгдэж байгаа "Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалтын үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланд дараах асуудлыг тусган зөвлөмж хэлбэрээр хүргүүлэхийг санал болгож байна. Үүнд:

1. Аудитын тайлангийн 1-р бүлэгийн 1.1-д "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 37-р зүйлийн 37.2-р заалтад заасны дагуу мэдээллийн санг уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга жил бүрийн 3-р сарын 1-ний дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ гэж заасныг анхаарах
2. Зөвлөмжид "Ашигт малтмалын тухай" хуулийн 33-р зүйлд заасан үүргийг биелүүлж байгаа байдлыг баталгаажуулах асуудлыг Ашигт малтмалын газарт
3. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт байгаа тусгай зөвшөөрлийг "Ашигт малтмалын тухай" хуулийн 14-р зүйлийн 14.1 заалтын дагуу шийдвэрлэх асуудлыг Засгийн газарт хандах харин зөвлөмжийн 4.1 заалтад заасан "...тусгай зөвшөөрлийг цуцлах..." үндэслэл гэдэгт аймгийн ИТХ-ын тогтоол хуулийн хугацаанд Ашигт малтмалын газарт хүргэгдсэн.
4. 2-р бүлгийн 2.1-д дурьдагдсан сумын ИТХ-аас гаргасан саналыг хуульд заасан үндэслэлээр БОНХ-ийн сайдад хандсан 4 дүгнэлт гаргаж өгөхөөс татгалзсан хариу хүргүүлсэн байгааг анхаарч зөвлөмжид оруулах зэрэг саналуудыг хүргүүлж байна.

Санал 1

Санал 2

Санал 3

Санал 4

ДАРГА



Р.ЖАРГАЛСАЙХАН



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС**

67123, Мөрөн, Хөвсгөл аймаг
Утас, факс: 70383283
www.khovsgol.gov.mn

2015.11.03 № 6/2327
танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Уул уурхайн нөхөн сэргээлтийн төвлөрүүлэлт, зарцуулалтын үр дүнд хийсэн тайлан дүгнэлттэй холбоотой санал байхгүй зөвлөмжинд нэмж тусгуулахаар дараах хоёр саналыг хүргүүлж байна.

-Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нар АМТ хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1 заасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх.

Санал 5

-Аймгийн Байгаль орчны газарт мэдээллийн санг хууль, журмын дагуу бүрдүүлэх, улсын мэдээллийн санд төвлөрүүлж байх

Санал 6

Зөвлөмжийг хэрэгжүүлж хяналт тавьж ажиллах болно.

ДАРГА



Х.ГАН-ОЧИР

• 04 0428

ТАЙЛБАР

- Санал 1. Танай саналыг хүлээн авч найруулгын хувьд дараах байдлаар өөрчлөв. “..... ЗДТГ-ын ХБХ, БОАЖГ нь улсын мэдээллийн санд төвлөрүүлэхээр заасан байтал өнөөдрийн байдлаар аймагт мэдээллийн сан байхгүй байгаагаас ямар мэдээллийг төвлөрүүлж байгаа нь тодорхойгүй байна.
- Санал 2. Танай саналыг хүлээн авч Ашигт малтмалын газарт өгөх зөвлөмжийн 1.3-т “Ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан үүргийн биелэлтийг баталгаажуулсан тайланг аймгийн БОАЖГ-т хүргүүлж байх” гэж оруулав.
- Санал 3. Өнөөдрийн хүртэл хариу ирээгүй байгаа тул зөвлөмжийг хэвээр үлдээв.
- Санал 4. БОНХ-ын сайдаас дүгнэлт гаргахаас татгалзсан хариу ирээгүй тул хэвээр үлдээгээд дараах тайлбарыг нэмж оруулав. БОНХЯ-аас ирүүлсэн тоотод *“Гоби эксплорэйшн ХХК, Монгол ресурс корпорацийн үйл ажиллагаатай холбогдох асуудлыг хянан үзэхэд, дээрхи аж ахуйн нэгжүүдийн эзэмшлийн ХҮ-016751, 10844Х дугаартай тусгай зөвшөөрлийн талбайн тодорхой хэсэг нь ойн сан бүхий газарт орсон байна.”* гэснээс харахад уг тусгай зөвшөөрөл нь Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны нөөц бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4.1, 4.5 дах заалтыг зөрчин тусгай зөвшөөрлийг олгосон байна.
- Санал 5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийсэн хуулийн этгээд хийх тул Зөвлөмжийн 6.1-д Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг холбогдох газраар батлуулан, хүргүүлж байх.”-аар заасан байгаа.
- Санал 6. Зөвлөмжийн 3-6-д тусгасан байгаа.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬАА ХӨВСГӨЛ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

67123, Мөрөн, Хөвсгөл аймаг
Утас: 70383793

2015. 11. 04 № 4АТ-ТАТ/2015/05-ТА/ААТ-11/23

ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ
ДАРГА А.ДАВААДОРЖ-Д

Зөрчил арилгуулах тухай

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудитор Хөвсгөл аймгийн аудитын газраас 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу "Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалтын үр дүн"-д гүйцэтгэлийн аудит хийхэд:

Цэцэрлэг сумын нутагт хайгуулын үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжээс 2013, 2014, 2015 онуудад нийт 8,450,000 /Найман сая дөрвөн зуун тавин мянган/ төгрөг төвлөрснөөс Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-04 дүгээр тушаалаар батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журамын 5.5 "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг энэхүү журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно" заалтыг зөрчин 4,831,490 /Дөрвөн сая найман зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун ерэн/ төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Иймд: Монгол улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэхь хэсгийн 12-т заасан (... аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах, акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээг тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих ...) заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, тусгай дансанд байршуулсан 8450,000 /Найман сая дөрвөн зуун тавин мянган/ төгрөгөөс зориулалт бусаар зарцуулсан 4,831,490/Дөрвөн сая найман зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун ерэн/ төгрөгийг 2015 оны 12 дугаар сарын 25-ны дотор Цэцэрлэг сумын байгаль хамгаалах сангийн 171855405 тоот дансанд төвлөрүүлэн, хариу мэдэгдэхийг Засаг дарга А.Давваадоржид даалгасугай.

АКТ ТОГТООСОН:
ШИНЖЭЭЧ

Э.БАТ-ЭРДЭНЭ

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:
ДАРГА

А.ДАВААДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬЯА ХӨВСГӨЛ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

67123, Мөрөн, Хөвсгөл аймаг
Утас: 70383793

2015. 11. 04 № 4АТ-ТАТ/2015/05-ТА/20ААТ-11/24

БҮРЭНТОГТОХ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.НАМУУНЦЭЦЭГ-Т

Зөрчил арилгуулах тухай

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторт Хөвсгөл аймгийн аудитын газраас 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу "Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалтын үр дүн"-д гүйцэтгэлийн аудит хийхэд:

Бүрэнтогтох сумын нутагт хайгуулын үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжээс 2013, 2014, 2015 онуудад нийт 10,000,000 /Арван сая/ төгрөг төвлөрснөөс Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-04 дүгээр тушаалаар батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын 5.5 "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг энэхүү журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно" заалтыг зөрчин 797,022 /Долоон зуун ерэн долоон мянга хорин хоёр/ төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Иймд: Монгол улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэхь хэсгийн 12-т заасан (... аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах, акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээг тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих ...) заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, тусгай дансанд байршуулсан 10,000,000 /Арван сая/ төгрөгөөс зориулалт бусаар зарцуулсан 797,022 /Долоон зуун ерэн долоон мянга хорин хоёр/ төгрөгийг 2015 оны 12 дугаар сарын 25-ны дотор Бүрэнтогтох сумын байгаль хамгаалах сангийн 170455405 тоот дансанд төвлөрүүлэн, хариу мэдэгдэхийг Засаг дарга Б.Намуунцэцэгт даалгасугай.

АКТ ТОГТООСОН:
ШИНЖЭЭЧ

У.БАТ-ӨРДЭНЭ/

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:
ДАРГА

/Б.НАМУУНЦЭЦЭГ/